

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4."б", 29.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 23/14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар болон “Сити баз консалтинг” ХХК-ийн хооронд байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээнд зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих шалгагчдыг ажиллуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээ”-ний биелэлтийг шалгаж, үйл ажиллагааг сайжруулах санал боловсруулах үүрэг бүхий, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан гэрээний биелэлтийг дүгнэх, бусад арга хэмжээг шуурхай зохион байгуулж, үр дүнг 2021 оны 01 дүгээр сарын 26-ны дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг /Х.Гантулга/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны  
01 дүгээр сарын 14-ний өдрийн  
А/07 дугаар захирамжийн хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга  
Х.Гантулга

Гишүүд: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Н.Наранбаатар

Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын  
дарга О.Чинзориг

Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний  
газрын орлогч дарга Б.Эрдэнэболд

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль,  
эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн А.Ууганбаяр

Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний  
газрын Диспетчерийн албаны дарга Ц.Мягмар

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн  
мэргэжилтэн Ж.Оюунжаргал

Нарийн бичгийн  
дарга:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн  
мэргэжилтэн Д.Сайнхүү